



Засног тулмын хэвлэл
№ 06 дугаар сарын 21
№23 /644/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

**Гаалийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

757

Монгол Улсын Их
Хурлын тогтоол

**“Монгол мал” үндэсний
хөтөлбөр батлах тухай**

758

Монгол Улсын
Дээд шүүхийн
тогтоол

**Эрүүгийн хуулийн 15 дугаар
бүлгийн зарим зүйл, заалтыг
тайлбарлах тухай**

793

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- | | | |
|------|---|-----|
| 195. | Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 757 |
|------|---|-----|

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|------|---|------------------|
| 196. | “Монгол мал” үндэсний хөтөлбөр батлах тухай | Дугаар 23
758 |
|------|---|------------------|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | |
|------|------------------------------|------------------|
| 197. | Журам, жагсаалт батлах тухай | Дугаар 85
779 |
|------|------------------------------|------------------|

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- | | | |
|------|---|------------------|
| 198. | Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай | Дугаар 13
793 |
|------|---|------------------|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1 дэх хэсгийн “1 жилээс дээшгүй байна” гэсний өмнө “газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах талаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тос хайх, олборлох, ашиглахад зориулагдсан бараа болон иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоцны хувьд 3 жил 6 сар хүртэл, бусад барааны хувьд” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.2, 97.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар
хот**"Монгол мал" үндэсний хөтөлбөр
батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол мал" үндэсний хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2."Монгол мал" үндэсний хөтөлбөрийн хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т даалгасугай:

1/"Монгол мал" үндэсний хөтөлбөрийн эхний үе шат /2010-2015 он/-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2010 оны эхний хагас жилд багтаан боловсруулж, хэрэгжүүлж эхлэх;

2/сумын түвшинд мал эмнэлэг, үржлийн үйлчилгээг зохицуулах, хянах, мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын анхан шатны нэгжийг байгуулж, үйл ажиллагааг эхлүүлэх;

3/"Монгол мал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 3 хувиас багагүй байхаар тооцож жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж, хөрөнгийн дийлэнх хэсгийг хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хөдөө аж ахуйн хоршоог түшиглэн хэрэгжүүлэх;

4/"Монгол мал" үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлж байгаа гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Батбаяр/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА****Д.ДЭМБЭРЭЛ**

“МОНГОЛ МАЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Мал сүрэг нь Монгол Улсын үндэсний өвөрмөц, нөхөн сэргээгдэх баялаг, монголын соёл, уламжлалыг хадгалан авч яваа дэлхийн үнэт өв сан, тогтвортой хөгжлийн үндэс, эдийн засгийн тулгуурын нэг бөгөөд хүн амын амьжиргааны гол эх үүсвэр, хүнсний аюулгүй байдлын баталгаа, малчин өрхийн эдийн засгийн үндэс юм. Ийм учраас Монгол Улсын Үндсэн хуульд “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж заасан байна.

Нэг.Нийтлэг үндэслэл

Мал аж ахуй нь үндэсний эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортын орлогод онцгой байр суурь эзэлдэг уламжлалт салбар хэвээр байна. Тус салбарт 2008 оны байдлаар нийт ажиллагчдын 34.6 хувь нь ажиллаж, дотоодын нийт бүтээгдэхүүний 18.8 хувийг хөдөө аж ахуйгаас, үүний 86.9 хувийг мал аж ахуйн салбараас тус тус үйлдвэрлэж байна. Мөн экспортын нийт орлогын 10 хувийг уг салбараас оруулж байна.

Гэвч сүүлийн жилүүдэд мал сүрэг өссөн хэдий ч бэлчээрийн даац хэтэрсэн, малын төрөл хоорондын харьцаа алдагдсан, малын чанар буурсан, малаас хүнд дамжин халдварладаг зарим өвчний тархварын байдал өргөжин хүн, малын өвчлөл нэмэгдэх хандлагатай болсон, малын гоц халдварт өвчин шинээр болон дахин сэргэж байгаатай уялдан мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх нөхцөл хязгаарлагдмал байгаа зэрэг шийдвэрлэвэл зохих бэрхшээлтэй олон асуудал байна. Үүнээс гадна малчид өрхийн зохион байгуулалтын хэлбэртэй, тархай бутархай байгаагаас мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмж буурсан, үр ашиг нь багассан, байгаль, цаг уурын эрсдэл даах болон зах зээлд өрсөлдөх чадвар суларсан байна.

Хүн амын мах, сүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж байгаа ч үйлдвэрийн аргаар боловсруулж бэлтгэсэн махны хэмжээ нийт үйлдвэрлэлийн дөнгөж 7 хувь, сүүний 4 хувийг тус тус эзэлж байгаа нь туйлын чамлалттай байгаа юм.

Манай оронд байгалийн шалгарал, малчид, мэргэжилтнүүдийн уйгагүй зүтгэл, бүтээлч хөдөлмөр, шинжлэх ухааны үндэслэлтэй сонгон үржүүлгийн ажлын үр дүнд бий болсон 40 гаруй үүлдэр, үүлдрийн хэсэг, омог, хэвшлийн малаас гадна гадаад орноос ашиг шим арвинтай мал, өндөгний чиглэлийн тахиа, мах-өөхний хэвшлийн гахай авчирч үржүүлж



байгаа боловч тэдгээрийн генетик нөөцийг бүрэн ашиглаж чадахгүй байна.

Мал аж ахуйн салбарт зарцуулах төсвийн хөрөнгө бусад улс орнуудтай харьцуулахад бага, төсвийн зарлагын 1,0 хувьд ч хүрэхгүй байна. Өөрөөр хэлбэл, энэ салбарыг зах зээлд өрсөлдөх чадвартай салбар болгон хөгжүүлэхэд төрийн зохицуулалт хангалтгүй, хөрөнгө хүрэлцээгүй байна.

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон төрийн бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг тухайн орон нутагт зохион байгуулах, хувийн хэвшлийн мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мал сүргийн удам гарваль, ашиг шим, эрүүл мэндийн бүртгэлийг хөтлөх, мэдээлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих ажил сумын түвшинд огт хийгдэхгүй байна.

Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс бодлогын баримт бичиг олныг гаргасан боловч түүний хэрэгжилт өнөөгийн шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаагаас тус салбарын цаашдын тогтвортой хөгжлийг хангахын тулд цогц арга хэмжээг оновчтой авч хэрэгжүүлэх нь "Монгол мал" үндэсний хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/ боловсруулж хэрэгжүүлэх үндэслэл болж байна.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, тэргүүлэх чиглэл

Мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, зах зээлийн нөхцөлд өрсөлдөх чадвартай, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, экспортыг нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараахь тэргүүлэх чиглэлийг баримтална:

1.Монгол Улсын эдийн засгийн тулгуур салбар болох мал аж ахуйг төрөөс онцгой анхаарч, эрх зүй, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын нэн таатай орчин бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангаж, сайн засаглалыг хөгжүүлэх;

2.Малын үржлийн ажил, үйлчилгээг нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх;

3.Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэж, малын эрүүл мэндийг баталгаажуулах замаар нийгмийн эрүүл мэндийг

хамгаалах;

4.Уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх;

5.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа

3.1.Нэгдүгээр тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, эдийн засгийн эргэлтэд эрчимтэй оруулах тогтолцоог бий болгох эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.

3.1.1.Мал аж ахуйн салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох:

3.1.1.1.Бэлчээр ашиглах, хамгаалах, эзэмших, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийн хил заагийг тодорхой болгох талаархи эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.1.1.2.Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулж малын бүртгэлжүүлэлт, мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний нэгжийн чадавхийг сайжруулах эрх зүйн орчныг бий болгох;

3.1.1.3.Мал аж ахуйн хөгжлийн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, малчдын хөдөлмөрийн үнэлгээг сайжруулах, урамшуулах тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.1.1.4.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Газрын төлбөрийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай, Улсын нөөцийн тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.1.1.5."Мал эмнэлгийн ажил, үйлчилгээг сайжруулах стратеги, төлөвлөгөө", "Малын үржлийн ажил, үйлчилгээний стратеги төлөвлөгөө", "Тэмээ", "Бэлчээр, тэжээл", "Мах", "Сүү", "Ноос", "Ноолуур", "Арьс шир" дэд хөтөлбөрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх.



3.1.2. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэх, анхан шатны нэгжийг бэхжүүлэх:

3.1.2.1. сумдад мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний албыг бий болгож ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.2.2. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний анхан шатны нэгжийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтний хүрэлцээ хангамж, чадавхийг сайжруулахад төрөөс дэмжих;

3.1.2.3. малын удмын сан, эрүүл мэндийн холбогдолтой мэдээ, мэдээллийг олон улсын шаардлагад нийцүүлэх, мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийг хамарсан сүлжээ байгуулж, мэдээллийг шуурхай дамжуулах нөхцөлийг бүрдүүлэх.

3.1.3. Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, үйлдвэрлэлд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх:

3.1.3.1. аймаг, сум, баг, аж ахуйн нэгжийн захиалгаар мал эмнэлэг, үржлийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, тэдгээрийн хүрэлцээ, хангамжийг сайжруулах;

3.1.3.2. малчдыг бэлчээрийн мал маллаганы уламжлалт болон дэвшилтэт арга ухаанд сургаж мэргэшүүлэх, аж ахуйгаа үр ашгтай хөтлөх мэдлэгийг малчдад олгох зайны болон орон нутгийн сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

3.1.3.3. салбарын эрэлт хэрэгцээнд нийцэх дэвшилтэт технологийг дамжуулах, нутагшуулах, нэвтрүүлэх;

3.1.3.4. малын эмч, мал зүйч, туслах ажилтнуудыг мэргэжлээс шалтгаалах өвчний болон хөдөлмөрийн халдвартай, хүнд нөхцөлд ажиллаж байгаа бүлэгт хамруулахаар эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.1.3.5. мал аж ахуй, мал эмнэлгийн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд боловсруулсан цөм технологи, инновацийн үр дүнг нэвтрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, урамшуулах, санхүүжилт, төсөл, хөтөлбөрт идэвхтэй хамруулах.



3.2.Хоёрдугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

Мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлж, малын үржлийн ажил, үйлчилгээг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.

3.2.1. Монгол малын ашигтай онцлог шинж чанарыг тухайн үүлдэр, омог хэвшлийн баталгаажсан цөм сүргээр бататган сайжруулж, удам зүй, сонгон үржүүлгийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, биологийн боломжийг бүрэн ашиглах:

3.2.1.1.бэлчээрийн монгол малыг тухайн орон нутагт зохицсон ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омог, хэвшлийн цөм сүргийн малаар сайжруулах;

3.2.1.2.хангайн бүсэд үхэр, адуу, тал хээрийн бүсэд хонь, адуу, говийн бүсэд ямаа, тэмээ зонхилж, томоохон хот суурин газрын ойролцоо болон тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг тодорхой зорилго, чиглэлтэйгээр төрөлжүүлэн үржүүлэх;

3.2.1.3.монгол малын ашиг шимийн түвшинг бүсчилэн тогтоож, ашиглагдаагүй биологийн нөөц боломжийг илрүүлж, үржил селекцийн ажлыг зорилтот зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн явуулах;

3.2.1.4.бэлчээрийн мал аж ахуйд бүс нутгийн онцлог, ашиг шимийн чиглэлээс хамааран хээлтэгчийн эзлэх хувийн жинг тодорхой түвшинд байлган, малын төрөл хоорондын харьцаа, сүргийн зохист бүтцийг бүрдүүлэх.

3.2.2. Малын удмын санг хамгаалж, биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэн малын бүтээмжийг нэмэгдүүлэх:

3.2.2.1.малын удмын сангийн үндэсний цогцолбор бий болгож, монгол малын генийн санг хамгаалах, зохистой ашиглах, хадгалах, малын гүн хөлдөөсөн үр, хөврөл үр үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах, хүйс жолоодох технологийг нэвтрүүлэх;

3.2.2.2.тоо нь цөөрч, удмын сан нь алдагдахад хүрч байгаа үүлдэр, омгийн болон гойд ашиг шимт малын удмын санг хамгаалах, зохистой ашиглах, үрийн нөөцтэй болох ажлыг зохион байгуулах;



3.2.2.3.үржлийн мал, амьтан, тэдгээрийн үр, хөврөл үрийг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг хяналттай болгож, тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх;

3.2.2.4.зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан сүүний чиглэлийн үхэр, нарийн, нарийвтар ноост болон хурганы арьсны чиглэлийн хонь, ноосны чиглэлийн ямаа зэрэг үржлийн мал, амьтан, тэдгээрийн үр, хөврөл үрийг импортлохыг дэмжих, экспортлоход хяналт тавих;

3.2.2.5.технологи дамжуулах, нутагшуулах зорилгоор эдийн засгийн бүсүүдэд малын үржүүлэг, биотехнологийн салбар бий болгож, малын зохиомол хээлтүүлгийн үйл ажиллагааг өргөтгөх, явуулын үйлчилгээг олон улсын жишигт хүргэх;

3.2.2.6.үр төлийн чанараар шалгарсан гойд ашиг шимт хээлтүүлэгчийн үрийг зохиомол хээлтүүлэгт ашиглах, хөврөл үр шилжүүлэн суулгах зэрэг биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэн донор сүрэг бий болгож үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх.

3.2.3.Малын үржлийн ажил, үйлчилгээний чадавхийг сайжруулж, хүртээмж үр дүнг дээшлүүлэх:

3.2.3.1.малын үржлийн ажил, үйлчилгээний оновчтой тогтолцоог орон нутгийн түвшинд бий болгож, үйл ажиллагааг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх;

3.2.3.2.малын үржлийн ажил, үйлчилгээний нэгж, түүний үйл ажиллагааны стандартыг бий болгож, үйлчилгээний нэр төрлийг шинэчлэн тогтоож мөрдүүлэх;

3.2.3.3.бог малын хээлтүүлэгчийг чиглэлтэй өсгөн бойжуулах, гэрээ түрээсээр ашиглуулах, нийлүүлгийн бус үед тусгайлан ялган суурилж маллах зэрэг үйлчилгээ эрхлэгчдэд төрөөс хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

3.2.3.4.малын үржил селекцийн ажлыг мэргэжлийн байгууллагын удирдлага, хяналтын дор малын ашиг шимийн чиглэлд нийцүүлэн, удам гарваль, ашиг шимийн бүртгэл, мэдээлэлд тулгуурлан үржлийн ажлын төлөвлөлтийн дагуу явуулах;

3.2.3.5.малын төрөл, ашиг шимийн чиглэлийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг дэмжиж, төрийн зарим чиг үүргийн ажлыг гэрээгээр болон захиалгаар гүйцэтгүүлэх.



3.2.4.Малын бүртгэл, мэдээллийн сан, сүлжээг бий болгох:

3.2.4.1.мал сүргийг хувийн дугаартай болгон бүртгэлжүүлж, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл мэндийг тодорхойлох, бүртгэх, мэдээлэх, хянах тогтолцоог бий болгож, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх;

3.2.4.2.цөм сүрэг, жишигт тэнцсэн хээлтүүлэгчийг удам гарваль, ашиг шим, эрүүл мэндийн үзүүлэлтээр сум, аймаг, улсын түвшинд мэдээллийн сан бүрдүүлж, нэгдсэн сүлжээнд хамруулан хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

3.2.4.3.малын бүртгэл, мэдээллийн сан, сүлжээг бий болгох чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулахад мэргэжлийн чиглэлийн төрийн бус байгууллагын оролцоог дэмжих;

3.2.4.4.мал бүртгэлжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, программ хангамжийг бий болгож, мэдээллийн сүлжээг өргөтгөх, бүртгэлжүүлэлтийн ажилд дэвшилтэт технологи нэвтрүүлэх ажлыг олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэх;

3.2.4.5.үндэсний хэмжээнд заавал бүртгэгдэж мэдээлэгдэх малын өвчний жагсаалтыг гаргаж, өвчний гаралт, тархалтын мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, үнэлэх, тайлагнах, мэдээлэх сүлжээ байгуулан хэрэгжүүлэх;

3.2.4.6.малын удам гарваль, ашиг шимийн гарц, чанар, шилжилт хөдөлгөөн, эрүүл мэнд, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3.3.Гуравдугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

Эрүүл малаас цэвэр, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх нөхцөл бүрдэнэ.

3.3.1.Олон улсын худалдааны хориг бүхий малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэрэмжлүүлэх, тэмцэх арга хэмжээний бэлэн байдлыг өндөржүүлж, зооноз халдварт зарим өвчнөөс мал сүргийг эрүүлжүүлэх:

3.3.1.1.Монгол Улс үхрийн цээж, хонь, ямааны



цэцэг, үхрийн тархины эд сархиатах өвчнөөр тайван, өвчингүй, тус улсын баруун бүс нутаг шүлхийгээр намжмал, вакцин хэрэглээгүй статусыг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага/цаашид "DMAЭМБ" гэх-аар баталгаажуулах;

3.3.1.2. малын гоц халдварт, халдварт өвчний тандалт, хяналтыг тогтмолжуулж, эрсдэл бүхий бүс нутгийн мал сүргийг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулж, үр дүнг сайжруулан өвчнөөр тайван нөхцөлийг хадгалах;

3.3.1.3. мал сүргийг бруцеллөз, адууг ям, халдварт цус багасах, үхрийг лейкоз өвчнөөс бүрэн эрүүлжүүлэх;

3.3.1.4. шинээр болон дахин сэргэж байгаа хил дамжин халдварладаг малын гоц халдварт өвчний халдварлалт, эрсдэлийг бууруулахад шаардагдах хөрөнгө, материалын нөөцийг бүрдүүлж, шуурхай бэлэн байдлыг хангах;

3.3.1.5. байгаль орчин, хүн, малд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэн халдварт өвчний голомтыг устгах, ариутгал халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулж, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах.

3.3.2. Мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, мал эмнэлгийн ажил, үйлчилгээг адийн засаг, нийгмийн шаардлага, эрэлт хэрэгцээг бүрэн хангах түвшинд хүргэн сайжруулах:

3.3.2.1. бүсийн тулгуур болон аймгийн орон нутгийн хөгжлийн төв, мал эмнэлгийн нэгжийн лабораториудыг орчин үеийн өндөр мэдрэмж бүхий тоног төхөөрөмж, малын үзлэг, шинжилгээ, ангилалтын зөөврийн хашаагаар хангах, тэдгээрийн халдвар хамгаалал, био аюулгүй ажиллагааны чадавхийг сайжруулах;

3.3.2.2. сумдын дунд мал эмнэлгийн оношлогоо, шинжилгээний тусгай зориулалтын тоног төхөөрөмж бүхий хөдөлгөөнт лабораторийг бий болгож, малын өвчлөл, хорогдлын шалтгааныг тогтоох, шуурхай хариу авах арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.3.2.3. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэврийн магадлан шинжилгээнд олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг арга, технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний экспорт, импортод тавигддаг шаардлагыг хангах;

3.3.2.4. мал сүргийг дархлаажуулах ажлыг

лабораторийн түүвэр шинжилгээгээр тогтоож, мониторинг хийх замаар урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тооцох, эмч нарын хариуцлагыг өндөржүүлэх;

3.3.2.5.байгалийн голомтот болон шинээр дахин сэргэж байгаа малын өвчний тархвар, голомтыг бүртгэн мэдээлэх газар зүйн мэдээллийн [GIS] системийг нэвтрүүлэх.

3.3.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг олон улсын стандартын түвшинд хүргэх:

3.3.3.1.малын эм, биобэлдмэлд хийх сорилт, задлан шинжилгээний арга, технологийг олон улсын түвшинд хүргэх, малын эмийн чанар, аюулгүй байдлыг хангах;

3.3.3.2.шинээр болон дахин сэргэж байгаа малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин, оношлуурыг дотооддоо үйлдвэрлэн хэрэгцээг бүрэн хангах;

3.3.3.3.малын эмийн үйлдвэрүүдийн техник, технологийг шинэчилж, эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлд үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлж, малын эм, биобэлдмэлийн бүтээгдэхүүний чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэх;

3.3.3.4.малын эм, мал эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлэх тогтолцоо, сүлжээг бий болгох.

3.4 Дөрөвдүгээр тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

Уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эдийн засгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан Монгол Улсад бэлчээрийн малаж ахуйг зонхилон, эрчимжсэн мал аж ахуйг тодорхой бүс нутагт хязгаарлагдмал хүрээнд эрхлэн, бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, тэжээл үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах замаар мал аж ахуйн эрсдэлийг бууруулна.

3.4.1.Бэлчээрийн менежментийг сайжруулах:

3.4.1.1.бэлчээрийг зохистой ашиглах менежментийн нэгдсэн системийг бий болгож, дэд хөтөлбөр хэрэгжүүлэх, бэлчээр нутгийн ашиглалт, кадастрын зураглалыг бүс, аймаг, сумаар гаргаж, тухайн нутагт байх боломжтой малын тоо, төрлийг тогтоож, мэдээллийн сан бий болгох;



3.4.1.2.бэлчээрийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувийг улс, аймаг, сумын отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгон хамгаалалтад авч цаг хүндэрсэн үед ашиглах;

3.4.1.3.малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулах, бэлчээрийн даац хэтэрсэн нутагт байлгах малын тооны дээд хязгаарыг тогтоож, түүнээс давуулахгүй байлгах эдийн засгийн хөшүүргүүдийг бий болгох;

3.4.1.4.малчин болон мал бүхий иргэдээс малынх нь төрөл, бүс нутгийн онцлогийг харгалзан бэлчээр ашигласны төлбөр авах эрх зүйн орчныг бүрдүүлж, түүний тодорхой хэсгийг бэлчээр хамгаалах, сайжруулахад ашиглах;

3.4.1.5.эрчимжсэн мал аж ахуйн бүс нутгийг аймаг, нийслэл, сум бүр тогтоож мөрдүүлэх;

3.4.1.6.бэлчээрт хөнөөл учруулдаг мэрэгч амьтад, шавжтай байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглан тэмцэх;

3.4.1.7.уулуурхайнүйлажиллагаанынөлөөгөөр бэлчээр хомсдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг бэлчээр сайжруулах үйл ажиллагаанд зарцуулах.

3.4.2.Хадлан, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх:

3.4.2.1.бүрэн найрлагат тэжээлийн үйлдвэр болон орон нутгийн түүхий эдэд тулгуурласан бага оврын цех байгуулж тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх;

3.4.2.2.тэжээлийн нэг ба олон наст ургамал, уургийн агууламж ихтэй шинэ төрлийн таримал тариалах ажлыг өргөтгөх, газар тариалангийн дагавар бүтээгдэхүүнийг малын тэжээлд ашиглах технологийг боловсронгуй болгох;

3.4.2.3.өвс, тэжээлийг чанарыг нь алдагдуулахгүйгээр хадгалах баглаа, боодлын шинэ технологи нэвтрүүлэн өвөр багатай, чанар сайтай тэжээл бэлтгэж улсын болон орон нутгийн байнгын нөөц бүрдүүлэх;

3.4.2.4.аймаг, сум бүрт цаг агаарын нөхцөл хүндэрсэн үед ашиглах зориулалт бүхий өвс, тэжээлийн нөөцийн сан бий



болгох. Эхний ээлжинд орон нутгийн нөөцийг зарцуулах, нөөц хүрэлцэхгүй нөхцөлд улсын нөөцийн санг ашиглах;

3.4.2.5.хадлан бэлтгэх боломжгүй говийн аймгуудад хангайн бүсээс хадлангийн талбай ашиглуулж шаардагдах техникийг хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэх ажлыг зохион байгуулах.

3.4.3.Малын усны хангамжийг сайжруулах:

3.4.3.1.уст цэгийн хайгуул, судалгааны ажлыг орон нутгийн малчдын санал, санаачилгыг харгалзан улсын төсвийн хөрөнгөөр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, тухайн цэгт шинээр ус нөөцлөх сан бүхий худаг гаргах;

3.4.3.2.шинээр худаг гаргахад шаардагдах хөрөнгийн тодорхой хувийг ашиглагчдаас нь гаргуулах замаар ашиглагчдын хариуцлагыг өндөржүүлэх;

3.4.3.3.улсын төсвийн хөрөнгөөр шинээр гаргасан болон сэргээн засварласан худгийн цаашдын ашиглалт хамгаалалт, засварын ажлыг орон нутагт хариуцуулж, малчдын бүлэг, нөхөрлөл, хоршоонд гэрээгээр ашиглуулах;

3.4.3.4.цас, борооны усыг тогтоож, хөв, цөөрөм байгуулах, гар худаг гаргах, бэлчээрийн тодорхой хэсгийг усжуулах арга ажиллагаанд малчдыг сургах.

3.4.4.Мал аж ахуйн эрсдэлийг бууруулах чадавхи бий болгох:

3.4.4.1.уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлтөд зохицуулан мал аж ахуйг эрхлэх технологийг боловсруулж, малчдад эзэмшүүлэх сургалт, үзүүлэх сургуулийг зохион байгуулах;

3.4.4.2.цаг агаарын аюулт үзэгдлийн давтамж, байгалийн эрсдэл ихтэй говь, хээрийн бүсийн сумдад цаг агаарын гэнэтийн аюулыг тандах, мэдээлэх, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.4.4.3.малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгож давхар даатгалыг шинээр бий болгох, малчдад даатгалын ач холбогдлыг сурталчлан сайн дурын үндсэн дээр малаа даатгуулах сонирхлыг бий болгох;

3.4.4.4.түргэн өсөлттэй махны чиглэлийн



малыг үржүүлж, өсвөр насанд нь эрчимтэй бордон мах үйлдвэрлэх үр ашигтай арга, технологийг нэвтрүүлж, өвөлжих малын тоог цөөлөх;

3.4.4.5. говь, тал хээрийн бүсийн малчдад малын хашаа барихад нь төрөөс дэмжлэг үзүүлж, бог малыг 2 ээлжийн хашаатай болгох.

3.5.Тавдугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгож түүний чанараас хамаарсан эдийн засгийн хөшүүрэг бий болгон зорилтот зах зээлийг хөгжүүлнэ.

3.5.1.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн системийг боловсронгуй болгох:

3.5.1.1.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэлийн стандартчлалыг боловсронгуй болгох;

3.5.1.2.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

3.5.1.3.сум бүрт мал нядалгааны болон арьс ширний анхан шатны тордолт хийх цех байгуулж, мал, мах бэлтгэл, технологийн тээвэр бүхий борлуулалтын нэгдсэн сүлжээ бий болгох;

3.5.1.4.малын гаралтай уламжлалт түүхий эдээс гадна бусад дайвар бүтээгдэхүүний ашиглалтыг сайжруулж, стандартын дагуу бэлтгэн зах зээлд нийлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;

3.5.1.5.мал, малын гаралтай түүхий эдийн бэлтгэл, хадгалалт, тээвэрлэлтийн чанар, стандартын сургалтыг бүс нутагт зохион байгуулах, түүхий эд бэлтгэлийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх;

3.5.1.6.түүхий эд бэлтгэлийн нөөц, үнийн мэдээллийг төрөл, ангилал, чанарын үзүүлэлтээр сум, аймаг бүрээр сар бүр гаргаж мэдээллийн нэгдсэн сүлжээнд оруулж, малчид, бэлтгэн нийлүүлэгч болон хэрэглэгчдэд тогтмол мэдээлэх сүлжээ бий болгох, энэ ажилд орон нутгийн холбогдох байгууллагыг татан оролцуулж, тэдгээрийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх.

3.5.2.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний

чанараас хамаарсан эдийн засгийн урамшуулал бий болгон хэрэгжүүлэх:

3.5.2.1 малчдын үүсгэл санаачилгаар бэлчээрийн менежмент, хадлан, тэжээл үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэн нийлүүлэх, мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний чиглэлээр сумдад байгуулагдсан хоршоо, мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалт, зээл, татварын бодлогоор дэмжих;

3.5.2.2. мал аж ахуйн чиглэлийн дараахь үйл ажиллагаа эрхлэгчдэд төрөөс урамшуулал олгох:

- цөм сүргийн малыг үржүүлж, стандартын шаардлага хангасан удам гарваль нь тодорхой үржлийн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж зах зээлд борлуулсан иргэн, хуулийн этгээдэд;
- мал сүргээ халдварт өвчнөөс эрүүлжүүлж, даатгалд хамруулсан, гарал үүсэл нь тодорхой малын сүүг сүүний үйлдвэрт нийлүүлсэн, дээрхи нөхцөлийг ханган үйлдвэрийн аргаар нядалсан малын махыг бэлтгэн борлуулсан хоршооны гишүүн малчдад;
- өөрсдийн санаачилга, хөрөнгөөр цас, борооны усыг тогтоож, хөв, цөөрөм байгуулсан, худаг гаргасан иргэн, хуулийн этгээдэд.

3.5.2.3. түүхий эд бэлтгэлд стандартад заасан ангилал, зэрэглэлийн дагуу ялгавартай үнийн тогтолцоо бий болгох.

3.5.3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн маркетингийг сайжруулах, зорилтот зах зээлийг хөгжүүлэх:

3.5.3.1. мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн суурь судалгааг хийж, зорилтот зах зээлийг оновчтой тодорхойлох;

3.5.3.2. "Үйлдвэржүүлэлтийн бодлого"-ын хүрээнд малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг олон улсын жишигт хүргэх;

3.5.3.3. мал, малын гаралтай түүхий эдийн нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах, нэмэгдүүлэх, экспортыг дэмжих;

3.5.3.4. зарим үүлдрийн мал, малын гаралтай бүтээгдэхүүнийг газар зүйн заалтад бүртгүүлж, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх;

3.5.3.5. малчид, үйлдвэрлэгчид, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурлан зорилтот зах зээлд чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааг дэмжих;

3.5.3.6. алслагдмал болон гадагшаа гарцгүй бүс нутаг дахь малын гаралтай түүхий эдийн нөөцийг оновчтой ашиглах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх;

3.5.3.7. малчид, үйлдвэр эрхлэгчдийн шууд харилцааг дэмжих, биржийн сүлжээ бий болгох.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн.

4.1. Хөтөлбөрийг 2010-2021 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Эхний үе шатны үйл ажиллагааг богиносгосон хугацаанд 2 дэд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийн эхний үе шат /2010–2015 он/-нд 5 тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь үр дүнд хүрнэ:

4.2.1. мал аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, салбарын үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, технологи дамжуулах цогц бодлогыг хэрэгжүүлж, малыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх болон малын үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулан үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлт гаргах эрх зүйн орчин бүрдэнэ;

4.2.2. орон нутагт мэргэжлийн ажил, үйлчилгээний зохистой тогтолцоо бий болох, хүртээмж, чанар, үр дүн сайжирснаар мал аж ахуйн салбараас зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, чанартай, аюулгүй түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх, экспортын нөөцийг нэмэгдүүлэх боломж бүрдэн, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн өрхийн орлого, өөрөө өөрийгөө тэтгэх чадвар дээшилнэ;

4.2.3. ДМАЭМБ-аас Монгол Улс үхрийн цээж, хонь, ямааны цэцэг, үхрийн тархины эд сархинах өвчнөөр тайван, өвчингүй, тус улсын баруун бүс нутаг шүлхийгээр тайван, вакцин хэрэглээгүй статусыг баталгаажуулсан байна. Бруцеллез өвчнөөс үхэр, тэмээн сүргийг, баруун бүсэд богийг, адууг ям, халдварт цус багасах өвчнөөс эрүүлжүүлж, малын гоц халдварт, халдварт өвчнөөр тайван нөхцөлийг хадгална;

4.2.4. бэлтгээр ашиглах, эзэмших менежментийг



боловсронгүй болгох, хадлан, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, малын усны хангамжийг сайжруулах, мал аж ахуйн эрсдэлийг бууруулах замаар уур амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх чадавхийг бий болгоно;

4.2.5.мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээл, бэлтгэл, боловсруулалт, борлуулалтын оновчтой тогтолцоо бүрдэж, тэдгээрийг үнийн уналтаас хамгаалсан төрийн тогтвортой бодлого хэрэгжиж малчдын амьжиргааны түвшин нэмэгдсэн байна.

4.3.Хөтөлбөрийн хоёр дахь үе шат /2016 – 2021 он/-нд дараахь үр дүнд хүрнэ:

4.3.1.мал аж ахуйн хөгжлийн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих, урамшууллын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

4.3.2.нийт мал сүргийг бүртгэлжүүлж, мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүсэл, эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгож түүнд бүртгэлээр тавих хяналтын тогтолцоог бүрдүүлж, хүн амыг эрүүл, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах, экспортлох боломжтой болно. Малын удмын санг баяжуулах, хадгалах, хамгаалах, зохистой ашиглах нөхцөл сайжирч, импортыг орлох үржүүлгийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэн хэрэгцээг бүрэн хангана;

4.3.3.байгалийн голомтот болон шинээр дахин сэргэж байгаа малын өвчний тархвар, голомтыг бүртгэн мэдээлэх газар зүйн мэдээллийн систем нэвтэрч, малын эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх сүлжээ бий болж, лабораториудын үйл ажиллагааны чадавхийг сайжруулан, био аюулгүй байдлыг ханган гоц халдварт өвчнөөс сэргийлэх вакцин, оношлуурыг дотооддоо үйлдвэрлэж, бруцеллёзоор тайван орны статусыг хангана;

4.3.4.уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эдийн засгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлэх хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлэн байгалийн эрсдэлд автагдах явдлыг бууруулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ;

4.3.5.малын гаралтай түүхий эдийн нөөцийг дотооддоо бүрэн боловсруулж, экспортын баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжинө.



Тав.Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

5.1.Хөтөлбөрийн үндсэн шалгуур үзүүлэлт нь энэ хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлт болон дараахь үзүүлэлтээр тодорхойлогдоно:

Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	2008 оны түвшин	Хүрэх түвшин		
			2012 он	2015 он	2021 он
1.Нэгдүгээр тэргүүлэх чиглэл: Салбарын эрх зүй, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын нэн таатай орчныг бүрдүүлж, тогтвортой хөгжлийг хангах, мал аж ахуйн салбарт сайн засаглалыг хөгжүүлэх:					
1.1.Мал аж ахуйн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	-	-
1.2.Мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгжийг бэхжүүлэх:					
- төрийн үйлчилгээний алба	тоо	0	338	-	-
- хувийн хэвшлийн үйлчилгээний нэгж (шинээр).	тоо	751	60	75	135
1.3.Мал аж ахуйн мэргэжилтэн, малчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх:					
- шинээр бэлтгэх, давтан сургах мэргэжилтэн,	тоо	104	1272	1908	2120
- малчны түр сургууль төгсөгчид.	тоо	25	6800	10200	17000
2. Хоёрдугаар тэргүүлэх чиглэл: Малын үржлийн ажил, үйлчилгээг боловсронгуй болгож, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулан, биологийн төгс чанартай түүхий ад, бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх:					
2.1.Малын удмын санг хамгаалах ажлын хүрээнд:					
-малын удмын сангийн үндэсний цогцолбор	тоо	0	1	-	-
-бүсүүдэд байгуулагдах мал үржүүлэх, биотехнологийн салбар.	тоо	0	3	2	-
-зохиомлоор хээлтүүлэх мал	тоо	3200	16000	24000	120000



2.2.Дотооддоо үйлдвэрлэх, импортоор авах үржүүлгийн бүтээгдэхүүн: -дотооддоо үйлдвэрлэх үр, хөврөл үр - импортлох үр, хөврөл үр	тоо тоо	21000 7000	24000 20000	60000 30000	195000 -
2.3.Оны эхний малын тоо үүнээс: төрөл тус бүрээр: - тэмээ - адуу - үхэр - хонь - ямаа	мян.тол хувь хувь хувь хувь хувь	43288, 0,6 5,1 5,8 42,4 46,1	33343.4 0,8 6,4 7,7 44,9 40,2	35298.9 0,8 6,8 9,6 45,4 37,4	36475.6 0,9 8,2 13,8 45,1 32,0
2.4.Нэг малаас авах ашиг шим: - цэвэр, эрлийз үнээний сүү - ноолуур - нарийн,нарийвтар ноос - бүдүүн, бүдүүвтэр ноос	305 хоног/ кг грамм кг кг	1769 290 3,9 1,1	2217 290 4,1 1,2	2673 300 4,4 1,3	3200 310 4,9 1,5
2.5.Малын бүртгэл мэдээллийн сан, сүлжээг бий болгох: - сүлжээнд хамрагдах нэгж - бүртгэлжүүлэх мал, өссөн дүнгээр	тоо хувь	0 0,3	338 40	- 60	- 60
3.Гуравдугаар тэргүүлэх чиглэл: Мал эмнэлгийн ажил үйлчилгээг олон улсын жоншигт хүргэж, монгол малын эрүүл мэндийг баталгаажуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах.					
3.1.Монгол Улс дараахь өвчнөөр тайван, өвчингүй статусыг ДМАЭМБ-аас авах: - үхрийн цээж - үхрийн тархины эд сархинатах - шүлхий - хонь, ямааны цэцэг		0 0 0 0	серти- фикат серти- фикат -	серти- фикат -	серти- фикат



3.2.Малыг дараахь төрлийн өвчнөөс эрүүлжүүлэх: -үхэр, тэмээг бруцеллээ өвчнөөс -адууг ям өвчнөөс -адууг халдварт цус багасах өвчнөөс -сүүний үхрийг лейкоз өвчнөөс -бог малыг бруцеллээ өвчнөөс - бруцеллээс тайван бус нийт малчин өрх /одоо 3.5-11.7 хувь/	хувь хувь хувь хувь хувь хувь	98,0 97,5 99,3 75,0 99,5 7,6	98,5 99,5 99,8 85,0 99,6 2,5	100 100 100 100 99,7 0,3	- - - - 100,0 0,1
3.3.Малын гоц халдварт өвчний дэгдэлт гараагүй байх:	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	-	-
3.4.Сум, дүүрэгт мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн магадлан шинжилгээ хийх чадавхитай болох:	Лабораторийн тоо	120	112	106	-
3.5.Малын өвчний оношлогооны явуулын үйлчилгээ бий болгох:	тоо	0	25	-	-
3.6.Малын эм, биобэлдмэл /вакцин, оношлуур/-ийг дотооддоо үйлдвэрлэх:	хувь	70	75	85	100
4.Дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл: Уур амьсгал, байгаль экологийн өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрсдэл даах чадавхийг сайжруулах.					
4.1.Улс, аймаг, сумын отрын бүс нутгийн түвшинд хамгаалалтад авах бэлчээрийн хэмжээ:	хувь	0,5	2,0	5,0	10
4.2.Малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулан малын тосны дээд хязгаарыг /квот/ тогтоох:	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	+	-
4.3.Аймаг, сум бүрт өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех бий болгох:	тоо	38	150	150	-



4.4.Бэлчээр сайжруулах арга хэмжээ: - шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн тоо	тоо	1314	2400	3600	2686
- бэлчээрийн хортон, мэрэгч амьтантай тэмцэх талбай	мян.га	700,0	2000,0	3000,0	10000,0
4.5.Малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох: - малын индексжүүлсэн даатгалд хамрагдах малчин өрхийн тоо	хувь	3,3	10,0	15,0	20,0
4.6.Бэлтгэх тэжээлийн хэмжээ: - нийт үйлдвэрлэх тэжээл	тэж. нэгж, мян. тонн	560,5	616,5	700,0	900,0
-үйлдвэрийн аргаар бэлтгэх тэжээл	хувь	9,6	12	30	40,0
5.Тавдугаар тэргүүлэх чиглэл: Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, бэлтгэл, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, урамшуулал олгох замаар эдийн засгийн эргэлтийг хурдасгах.					
5.1.Мал нядалгааны цех бий болгох	тоо	25	313	-	-
5.2.Мах, нядалгааны жингээр нийт үйлдвэрлэх махны хэмжээ: Үүнээс: -үйлдвэрийн аргаар боловсруулах	мян.тн	223,1	256,3	353,8	324,0
- экспортод гаргах	мян.тн	15,1	34,8	70,8	157,0
	мян.тн	10,2	21,0	33,0	50,0
5.3.Нийт үйлдвэрлэх сүүний хэмжээ: Үүнээс: - үйлдвэрийн аргаар боловсруулах	мян.тн	457,3	447,9	523,8	622,9
	мян.тн	16,5	26,9	52,4	124,6



5.4 Дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлсэн, гарал үүсэл нь тодорхой бүтээгдэхүүнд чанараас хамааран урамшуулал олгох	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	-	
5.5 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний биржийн сүлжээ бий болгох	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	-	-	-	-

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг дараахь байгууллага хариуцна:

6.1.1.тер, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан хөтөлбөрийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах үүргийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр ахлуулсан Үндэсний хороо;

6.1.2.хөтөлбөрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг холбогдох төрийн захиргааны төв болон мэргэжлийн байгууллага;

6.1.3.хөтөлбөрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд удирдан зохион байгуулах, зохицуулах үүргийг тухайн шатны Засаг дарга, хэрэгжүүлэх ажлыг тухайн орон нутгийн мэргэжлийн байгууллага.

6.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр боловсруулж, үр дүнг жил бүр тооцож ажиллана.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана:

7.1.1. Улсын болон орон нутгийн төсөв;

7.1.2. Иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт;

7.1.3. Арилжааны бус хөнгөлөлттэй зээл, тусламж олгох "Монгол мал" хөрөнгө оруулалтын сан байгуулна.

7.2."Монгол мал" хөрөнгө оруулалтын санг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

7.2.1. ашигт малтмалын бүтээгдэхүүний орлого;

7.2.2. улсын төсөв;

7.2.3. гадаад улс, олон улсын буцалтгүй тусламж,



хөнгөлөлттэй зээл.

Найм. Хөтөлбөрийн тайлан, хяналт, шинжилгээ

8.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэл, сум, дүүргийн мэргэжлийн алба, газар жил бүрийн 1 дүгээр сард багтаан холбогдох төрийн захиргааны байгууллагад, хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь 1 дүгээр улиралд багтаан Засгийн газар, Улсын Их Хуралд тайлагнана.

8.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ, үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ өгөх ажлыг Засгийн газар хариуцна.

8.3.Шаардлагатай тохиолдолд хөтөлбөрийн явцын болон үе шатны хэрэгжилтэд эрх бүхий хөндлөнгийн байгууллага хяналт, шинжилгээ хийж Засгийн газарт тайлагнана.

8.4.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдалд үнэлгээ өгч тодотгол хийж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 4 дүгээр
сарын 7-ны өдөр

Дугаар 85

Улаанбаатар
хот

Журам, жагсаалт батлах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 34.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам"-ыг 1 дүгээр, "Байгаль орчны мэдээллийн сангийн эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1996 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 52 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАТБОЛД

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Л.ГАНСҮХ



Тав. Мэдээллийн санг хадгалах, хамгаалах

5.1. Байгаль орчны мэдээллийн төв нь мэдээллийг архивлах, хадгалах, хамгаалах ажлыг хариуцна.

5.2. Байгаль орчны мэдээллийн төв нь байгалийн гамшиг, гал усны болон гэнэтийн бусад аюул, халдлага, устаж үрэгдэж болзошгүй бусад нөлөөллөөс хамгаалах зорилгоор мэдээллийн санд байгаа өгөгдөл, мэдээллийг жил бүр хувилж, аюулгүй байдлын болон техникийн шаардлага хангасан газарт хадгална.

5.3. Иргэн, хуулийн этгээд нь улсын төсөв, шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр бүрдүүлсэн байгаль орчны өгөгдөл, мэдээллийн нэгдсэн тооллыг жилд нэгээс доошгүй удаа хийж дүнг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.4. Мэдээллийн санд мэдээлэл бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах компьютер болон серверийг мэдээллийн аюулгүй байдал хангах чиглэлээр бүх талаар хамгаалах арга хэмжээ авсан байна.

5.5. Мэдээллийн сангийн компьютер, түүнтэй сүлжээгээр холбогдох бусад компьютер, тэдгээрийг дагалдах техник хэрэгсэл, программ хангамжийг засварлах, шинээр нэмж эд анги суурилуулах, өөрчлөх болон шаардлагатай бусад үйлчилгээ хийхдээ зөвхөн мэдээллийн сүлжээ хариуцсан мэргэжилтний хяналтын дор мэргэжлийн итгэмжлэгдсэн ажилтан гүйцэтгэнэ.

5.6. Мэдээллийн санг бүрдүүлэх компьютерийн хэрэглэгч нууц түлхүүртэй байна.

5.7. Байгаль орчны мэдээллийн төв нь мэдээллийн санд хийсэн өөрчлөлтийн талаар бүртгэл, тайлан хөтөлнө.

Засгийн газрын 2010 оны 85 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЭХ МЭДЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ЖАГСААЛТ

1. Газар, түүний хөрсний эх мэдээ:

1.1. Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн тоон болон зураг талбайн хэмжээ



1.2. Газрын нэгдмэл сангийн ангиллаар газар нутгийн хэмжээ:

1.2.1. Хөдөө аж ахуйн газар:

1.2.1.1. бэлчээр газар

1.2.1.2. хадлангийн газар

1.2.1.3. тариалангийн газар, үүнээс:

-уриншилсан

- атаржсан

1.2.1.4. талхлагдсан хөдөө аж ахуйн газар.

1.2.2. Хот, суурингийн газар:

1.2.2.1. барилга байгууламжийн

1.2.2.2. нийтийн эдэлбэрийн

1.2.2.3. үйлдвэрийн дэвсгэр газар

1.2.2.4. уурхайн эдэлбэр газар

1.2.2.5. иргэний эзэмшил газар

1.2.2.6. иргэний өмчлөлийн газар

1.2.2.7. аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил,
ашиглалтын газар

1.2.2.8. чөлөөт бүсийн газар

1.2.3. Зам, шугам сүлжээний газар:

1.2.3.1. автозамын газар

1.2.3.2. төмөр замын газар

1.2.3.3. агаарын тээврийн эзэмшлийн газар

1.2.3.4. дулааны шугам сүлжээний эзэмшлийн газар

1.2.3.5. усан хангамжийн сүлжээний эзэмшлийн газар

1.2.3.6. цахилгаан дамжуулах шугам сүлжээний газар

1.2.3.7. холбоо, мэдээллийн зориулалтаар олгосон
газар

1.2.3.8. нийтийн эдэлбэрийн бусад газар

1.2.4. Ойн сан бүхий газар:

1.2.4.1. ой, мод, загтай газрын талбай

1.2.4.2. ой модыг огтолсон талбай

1.2.4.3. ойн цоорхой, зурвас газрын талбай

1.2.4.4. ойг нөхөн сэргээхэд зориулсан газрын талбай

1.2.4.5. ой тэлэн ургах боломжийг хангахуйц газрын
талбай

1.2.5. Усан сан бүхий газар:

1.2.5.1. нуурын талбай



- 1.2.5.2. цөөрөм, тойрмын талбай
- 1.2.5.3. гол мөрөн булаг, шандын талбай
- 1.2.5.4. мөнх цас, мөсөн голын эзлэх талбай

1.2.6. Улсын тусгай хэрэгцээний газар:

- 1.2.6.1. улсын хилийн зурвас газар
- 1.2.6.2. улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар
- 1.2.6.3. гадаадын дипломат төлөөлөгчдийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар
- 1.2.6.4. аймаг дундын отрын бэлчээрийн газар
- 1.2.6.5. улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай
- 1.2.6.6. улсын тусгай хамгаалалттай газар
- 1.2.6.7. шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын газар
- 1.2.6.8. бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт газар

1.2.7. Доройтож талхлагдсан газар:

- 1.2.7.1. талхлагдсан газрын төрөл, хэмжээ
- 1.2.7.2. өнгөн хөрсийг хуулж, үхсэн талбай
- 1.2.7.3. мэрэгчид, үлийн цагаан оготнод идэгдсэн талбай
- 1.2.7.4. хог хаягдал, овоолгын шороогоор хучигдсан талбай
- 1.2.7.5. цөлжсөн талбай;
- 1.2.7.6. элсний нүүдэлд нэрвэгдсэн талбай

2. Газрын хэвлий, ашигт малтмалын эх мэдээ:

- 2.1. геологийн судалгааны ерөнхий мэдээлэл
- 2.2. ашигт малтмалын нөөц, жил бүрийн олборлолтын мэдээ
- 2.3. ашигт малтмалын хайгуул, олборлолт явуулж байгаа хуулийн этгээдийн талаархи мэдээлэл
- 2.4. иргэн, хуулийн этгээдийн ашиглаж байгаа газрын хэвлийн кадастрын зураг
- 2.5. газрын хэвлийн нөхөн сэргээлт
- 2.6. газар доорхи барилга, байгууламж

3. Ус, рашааны эх мэдээ:

- 3.1. гол мөрөн, горхи, булаг шанд, нуур, цөөрөм, тойром, баян бүрдийн тоо
- 3.2. намгархаг усан орчны талбай
- 3.3. улсын чанартай рашааны төрөл тоо
- 3.4. орон нутгийн чанартай рашаан, сувиллын газрын тоо
- 3.5. гадаргын болон газар доорхи усны нөөц, чанар, байршил, тэдгээрийн өөрчлөлтийн талаархи хайгуул судалгааны дүн
- 3.6. ус, рашааны тойм болон бусад зураг
- 3.7. рашаан, эрдэст нуур, эмчилгээний шаврын нөөц, чанар, найрлага, тэдгээрийн өөрчлөлт, ашиглалттай холбогдсон судалгааны дүн
- 3.8. бохирдсон ус, рашааны нэр, байршил, түүний усны нөөц
- 3.9. үер, усны хор хөнөөлийн дүн мэдээ
- 3.10. усны нөөц ашиглагч иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, төлбөр, хураамжийн орлого
- 3.11. усны нөөц ашиглалт, хаягдал усны хэмжээ, найрлага, ус ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдол бүхий барилга байгууламж, тоног, төхөөрөмжийн тоо, хүчин чадал
- 3.12. усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, төлбөр, орлого

4. Ойн сангийн эх мэдээ:

- 4.1. ойн сан бүхий газрын талбай
- 4.2. ойгоор бүрхэгдсэн газрын талбай
- 4.3. мод үржүүлгийн тарьц, суулгац бойжуулах газар
- 4.4. ойн цоорхой
- 4.5. ойн захаас гадагш 100 метрт орох бүсийн талбайн хэмжээ
- 4.6. модыг огтолсон талбай
- 4.7. ойн нөөц, бүрэлдэхүүн, тэдгээрийн өөрчлөлт
- 4.8. ойн тойм болон тархацын зураг
- 4.9. ойн түймрийн тоо, түймэрт нэрвэгдсэн талбайн хэмжээ, зураг
- 4.10. ойн хөнөөлт шавьжийн төрөл зүйл, тархалт, түүнд нэрвэгдсэн ойн талбай
- 4.11. ойн арчилгаа, цэвэрлэгээний ажлын тоо, хэмжээ
- 4.12. ойн нөхөн сэргээлт, байгалийн сэргэн ургалтад туслах арга хэмжээ, ойжуулсан талбай, тарьж суулгасан мод, сөөгний төрөл, тоо хэмжээ



- 4.13. ирган, хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлсэн ойн талбай
- 4.14. ойгоос бэлтгэж ашигласан түлшний модны хэмжээ, түүний төлбөрийн орлого

5. Байгалийн ургамлын эх мэдээ:

- 5.1. ургамлын аймгийн сан, түүний ангилал
- 5.2. гуурст ургамал, түүний зүйлийн бүрэлдэхүүн
- 5.3. нэн ховор, ховор, элбэг, үлдвэр, ургамлын тархац, нөөцийн хэмжээ, түүний үнэлгээ, тэдгээрийн нэрсийн жагсаалт
- 5.4. усны ургамлын тархац, нөөцийн хэмжээ
- 5.5. хөвдийн тархац, нөөцийн хэмжээ
- 5.6. замагны тархац, нөөцийн хэмжээ
- 5.7. мөөгний тархац, нөөцийн хэмжээ
- 5.8. ургамлын судалгааны дүн мэдээ
- 5.9. ургамлын хяналт-шинжилгээ, ажиглалт, хэмжилтийн дүн мэдээ
- 5.10. ургамал ашигласны төлбөр тооцох үзүүлэлт, төлбөрийн хэмжээ
- 5.11. хүнс, тэжээл, эм, техникийн болон бусад ашигт ургамлын газрын доорхи, дээрх биомасс, ургацын хэмжээ, бүтээмж
- 5.12. хадлан, бэлгээрийн ургамалжилтын зураг, түүний тайлбар, геоботаникийн бичиглэл
- 5.13. байгалийн ургамлын экспортын тоо хэмжээ
- 5.14. ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, улаан номд орсон ургамлын жагсаалт, тэдгээрийн экспорт, импорт
- 5.15. ургамал хамгаалал, ургамлын хөнөөлт шавьж, түүний тархац, хогийн ургамлын тархац, тэдгээрийн хор хөнөөл, түүнтэй тэмцсэн ажлын дүн
- 5.16. нэн ховор, унаган буюу үлдвэр ургамлын удмын санг хамгаалах зорилгоор ургамлыг тарималжуулж, нутагшуулж байгаа мэргэжлийн байгууллагын тоо, ажлын тайлан, судалгааны дүн
- 5.17. ургамлыг гал түймрээс хамгаалах талаар авсан арга хэмжээ
- 5.18. ургамлын өвчлөлийн судалгааны дүн, хамгаалахаар авсан арга хэмжээ
- 5.19. ургамлыг хөнөөлт мэргэгчид, хортон шавьжаас хамгаалах талаар авсан арга хэмжээ



- 5.20. ургамлыг химийн бодисын хортой нөлөөллөөс хамгаалах, хорио цээр тогтоох талаар авсан арга хэмжээний дүн мэдээ
- 5.21. тарималжуулсан байгалийн ургамлын төрөл зүйл, талбай
- 5.22. ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан газрын хэмжээ, нөхөн сэргээсэн дүн
- 5.23. үйлдвэрийн зориулалтаар ашигласан ургамлын тоо хэмжээ
- 5.24. судалгаа, шинжилгээний зориулалтаар ашигласан ургамлын тоо, хэмжээ
- 5.25. ахуйн зориулалтаар ашигласан ургамлын тоо, хэмжээ
- 5.26. эмийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан тоо, хэмжээ
- 5.27. ургамлын генийн болон эд эсийн цуглуулга, лабораторид хадгалсан үр хөврөл

6. Амьтны аймгийн эх мэдээ:

- 6.1. амьтны аймгийн ангилал зүй, зүйлийн бүрэлдэхүүн, тархац нутаг, нягтшил
- 6.2. ан амьтны нөөц, тоо толгой, сүргийн бүтэц, нөхөн үржил, жилийн цэвэр өсөлт, бууралт, амьтны шилжилт хөдөлгөөн
- 6.3. жилд агнасан, барьсан болон гадаадад гаргасан амьтны төрөл зүйл, тоо хэмжээ, илрүүлсэн зөрчлийн тоо, хэмжээ
- 6.4. ан амьтны өвчний судалгаа, байгалийн голомтот халдварт өвчний тохиолдол, тархалт, хор хөнөөл
- 6.5. ан амьтны экологи, эдийн засгийн үнэлгээ
- 6.6. амьд амьтны генийн болон эд, эсийн цуглуулга, лабораторид хадгалсан үр хөврөл
- 6.7. амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, нутагшуулах талаар авсан арга хэмжээний дүн, зардал
- 6.8. амьтны аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, Улаан номонд орсон амьтдын жагсаалт, тэдгээрийн экспорт, импортын дүн
- 6.9. ан амьтныг хамгаалахад зориулсан биотехникийн арга хэмжээний дүн
- 6.10. агнуурын нөөц, ашиглалт, ан агнуурын нөөц ашигладаг эрх бүхий этгээдийн бүртгэл, төлбөр хураамжийн орлого
- 6.11. амьтны аймгийн амьдрах орчинд гарсан өөрчлөлтийн тухай дүн мэдээ



7. Агаар, орчны бохирдлын эх мэдээ:

- 7.1. агаарын үндсэн хийн агууламж, агаар дахь бохирдуулагч бодисын хэмжээ, стандарт болон хүлцэх хэмжээ
- 7.2. агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоо, хүчин чадал, ялгарах хүлэмжийн хийн хоногийн хэмжээ
- 7.3. агаарын бохирдлыг хянах цэгийн байршил, тоо
- 7.4. үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан, савласан агаарын хэмжээ
- 7.5. озоны давхаргад хортой нөлөө үзүүлэх бодисын жагсаалт, түүний үйлдвэрлэл, импортын дүн, тоо, хэмжээ
- 7.6. агаар дахь хүлэмжийн хийн агууламж
- 7.7. озоны давхаргын төлөв байдал, нарны хэт ягаан туяаны эрчмийн өөрчлөлтийн хяналт-шинжилгээ
- 7.8. агаар дахь хүчлэлэг тунадас, цацраг идэвхжилтийн хэмжээний өөрчлөлтийн дүн
- 7.9. агаар, ус, хөрсний бохирдолтоос үүсэх сөрөг нөлөөлөл
- 7.10. орчныг бохирдуулагч нэгжийн талаархи мэдээ, төлбөр

8. Уур амьсгалын эх мэдээ:

- 8.1. уур амьсгал, цаг агаарын прогноз, цаг агаарын төлөв байдлын 7, 10 хоногийн болон сарын урьдчилсан мэдээ
- 8.2. агаар, хөрсний температур, чийгшил, хур тунадас, салхины жилийн дундаж хэмжээ
- 8.3. уур амьсгалын дулаарлын үзүүлэлт, төлөв
- 8.4. цаг агаарын аюултай үзэгдэл, түүний ангилал, төрлөөр:
 - цасан шуурга, зуд;
 - хүйтэн бороо, аянга, үер;
 - шороон шуурга;
 - ган;
 - хэт их халалт;
 - хүчтэй салхи.

9. Байгалийн гамшгийн эх мэдээ:

- 9.1. байгалийн гамшигт үзэгдлийн төрөл, тодорхойлолт
- 9.2. байгалийн гамшигт үзэгдлийн тохиолдол, давтамж, хамрагдсан нутаг дэвсгэр
- 9.3. байгалийн гамшигт үзэгдлийн эмзэг байдал, эрсдэлийн



үнэлгээ

- 9.4. байгалийн гамшигт үзэгдлийн хор уршиг, хохирол
- 9.5. байгалийн гамшигт үзэгдэлтэй тэмцэхэд зарцуулсан зардал, хөрөнгийн хэмжээ

10. Химийн хорт болон аюултай бодисын эх мэдээ:

- 10.1. химийн хорт болон аюултай бодисын ангилал
- 10.2. олон улсад болон Монгол Улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүний жагсаалт, ашиглалтын хүрээ, хорт бодисын нэгж агууламж, хүлцэх хэмжээ
- 10.3. химийн хорт болон аюултай бодисын хор, аюулын лавлах мэдээлэл
- 10.4. Монгол Улсад ургамал хамгаалал, мал эмнэлэг, ариутгал, халдваргүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт
- 10.5. ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалт
- 10.6. химийн хорт болон аюултай бодисын улсын нэгдсэн тоо бүртгэл, тооллогын дүн
- 10.7. химийн хорт болон аюултай бодисын импорт, экспорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, устгалын дүн мэдээ
- 10.8. химийн хорт болон аюултай бодистой холбоотой гарсан аюул, ослын тохиолдол, учирсан хор хохирлын хэмжээ

11. Хог, хаягдлын эх мэдээ:

- 11.1. аюултай хог, хаягдлын улсын бүртгэл, дүн мэдээ
- 11.2. хог, хаягдлын ангилал, зайлуулах цэгүүдийн байршил, талбайн хэмжээ
- 11.3. ялгарсан ахуйн болон үйлдвэрлэлийн хог, хаягдлын тоо хэмжээ
- 11.4. эмнэлгийн хог, хаягдал зэрэг тусгай ангиллын хог хаягдлын устгалын мэдээ
- 11.5. хогийн цэгүүдэд цуглуулсан, тээвэрлэсэн, зайлуулсан, ангилсан, ашигласан, дарж булсан хог, хаягдлын тоо, хэмжээ
- 11.6. хог, хаягдлын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, хог, хаягдал

гаргасны төлбөрийн орлого

11.7. аюултай хог, хаягдлыг экспортлох эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээ

12. Тусгай хамгаалалттай газар нутгийн эх мэдээ:

12.1. тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэс болон газрын зургийг дархан цаазат, байгалийн цогцолборт, байгалийн нөөц, дурсгалт газрын ангиллаар

12.2. орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хилийн цэс болон газрын зураг

12.3. тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалтын талаархи тайлан, мэдээ

12.4. тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс нутгийн газрын зураг

12.5. тусгай хамгаалалттай газар нутаг дахь аялал жуулчлал эрхлэгчдийн тоо, ажлын үзүүлэлт

12.6. тусгай хамгаалалттай газар нутагт явагдсан судалгаа, шинжилгээний ажлын тайлан

12.7. тусгай хамгаалалттай газар нутаг дахь байгалийн дагалт болон баялаг ашиглалт, орлогын мэдээ

12.8. тусгай хамгаалалттай газар нутаг дахь биологийн төрөл зүйлийн нэр, тархац, нөөц

12.9. тусгай хамгаалалттай газарт газар ашиглаж үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрөл, гэрээний дугаар, хугацаа

12.10. тусгай хамгаалалттай газар нутаг дээр хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо, мэдээ

12.11. тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжүүлж байгаа менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, шинэчлэлтийн талаархи мэдээ

13. Байгаль орчны эрх зүйн эх мэдээ:

13.1. байгаль орчны холбогдолтой олон улсын гэрээ

13.2. байгаль орчны холбогдолтой хууль тогтоомж

13.3. төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газрын агентлагаас нийтээр дагаж



мөрдүүлэхээр гаргасан шийдвэр

13.4. байгаль орчны олон улсын болон үндэсний стандарт

14. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний эх мэдээ:

- 14.1. байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний тайлан
- 14.2. үнэлгээ хийлгэсэн төслийн төвч тодорхойлолт, кадастрын зураг
- 14.3. байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр
- 14.4. байгаль орчны төлөв байдлын үндсэн үзүүлэлтүүд
- 14.5. холбогдох мэргэжлийн хяналт, аудитын байгууллага болон улсын байцаагчаас хийсэн шалгалт, мониторингийн дүн
- 14.6. олон нийт, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол
- 14.7. нөхөн сэргээлтийн тайлан, зураг, байршуулсан барьцааны болон зарцуулсан хөрөнгө
- 14.8. байгаль орчны үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагын нэр, хаяг

15. Байгаль орчны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн эх мэдээ:

- 15.1. Улсын Их Хурлаар батлагдсан бодлого, хөтөлбөрийн жагсаалт, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах нэгж, хамрах хүрээ, хэрэгжилтийн түвшин
- 15.2. Засгийн газраар батлагдсан бодлого, хөтөлбөрийн жагсаалт, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах нэгж, хамрах хүрээ, хэрэгжилтийн түвшин
- 15.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, байгаль орчны асуудлаар дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, нэгж хамрах хүрээ, хэрэгжилтийн түвшин
- 15.4. байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн хөтөлбөр, түүний хэрэгжилтийн түвшин
- 15.5. байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон улсын төслийн нэр, хэрэгжилтийн хугацаа, хэрэгжүүлэгч нэгж, хамрах хүрээ, явц, үр дүн



15.6. бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал

16. Байгаль орчны статистик мэдээлэл, тайлангийн эх мэдээ:

16.1. байгалийн нөөцийн статистик үзүүлэлт

16.2. орчны бохирдлын статистик үзүүлэлт

16.3. байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийн статистик

17. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын эх мэдээ:

17.1. байгаль орчны чиглэлээр тухайн жилд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалтын дүн

17.2. олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалт

17.3. орон нутгийн төсвөөс байгаль орчинд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт

17.4. иргэн, хуулийн этгээдийн байгаль орчны зориулалтаар зарцуулсан төсөв, хөрөнгийн зарцуулалт

17.5. байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал, төсвийн дүн мэдээ

18. Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөцийн эх мэдээ:

18.1. байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, хүний нөөц

18.2. байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эрдэм шинжилгээний байгууллага, хүний нөөц

18.3. байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, хүний нөөц

18.4. байгаль орчин, үнэлгээний болон мэргэжлийн байгууллагын эрх авсан аж ахуйн нэгж, байгууллага, хүний нөөц

18.5. байгаль орчны тодорхой асуудал хариуцан ажилладаг зөвлөл, хүний нөөц

18.6. байгаль орчны чиглэлээр сургалт эрхэлдэг их, дээд сургууль, коллеж, хүний нөөц

18.7. байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа нөхөрлөл, хүний нөөц.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2010 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 15 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн талаар заасан Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн /цаашид хуулийн гэх/ 92 дугаар зүйлийн 92.1-д заасан “сэтгэл санааны гүнзгий хямрал” нь хувийн /хүсээгүй жирэмслэлт, бусдаас айж, эмээх г.м/ болон ахуйн /орон гэргүй, тэжээн тэтгэх санхүүгийн боломжгүй г.м/ эсхүл нийгмийн /дайн, байлдаан болж байгаа, зэвсэгт бослого гарсан г.м/ шинжтэй нөхцөл байдлаас үүссэн сэдэлттэй байна.

Сэтгэл санааны гүнзгий хямрал нь төрөхөөс өмнө, төрөх явцад болон төрсний дараа үүссэн байх нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

2. Мөн зүйл, хэсэгт заасан “нярай” гэж төрснөөсөө хойш нярайд илрэх шинж нь арилаагүй байгаа буюу хоёр хоногоос хэтрээгүй хүүхдийг хэлнэ.

Хоёр хоногоос дээш настай хүүхдийг алсан бол Эрүүгийн хуулийн 92 дугаар зүйлээс өөр аль тохирох зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

3. Хуулийн 94 дүгээр зүйлд заасан хөнгөмсгөөр найдсан, эсхүл хайхрамжгүй хандсаны улмаас бусдыг болгоомжгүй алах гэмт хэргийг хүнийг шууд бус санаатай алах үйлдлээс ялгаж зүйлчлэхэд анхаарвал зохино.

Энэ хоёр үйлдэл нь хүний амь хохироосон үр дагаварт хүргэсэн санаа, зорилгоороо ялгагдана.

4. Хуулийн 95 дугаар зүйлийн 95.1, 101 дүгээр зүйлийн 101.2-т тус тус заасан “өөр байдлаар эрхшээлдээ байгаа” гэдэгт эд хөрөнгө, албан



тушаалаас бусад нөхцөл байдлын улмаас тухайн этгээдээс хараат байхыг ойлгоно.

Хуулийн 95 дугаар зүйлийн 95.1-д заасан “**өөр бусад хүмүүс**” гэдэгт тухайн гэмт хэргийн улмаас хохирсон хэн ч хамаарч болно.

5. Энэ зүйл, хэсэгт заасан “**харгис хэрцгий харьцсан**” нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг /гарчлаах, бие махбодид нь гэмтэл учруулах г.м/ үйлдэх болон бусад хэлбэрээр /хүнийг хууль бусаар хорих, сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт хууль бусаар байлгах, бэлгийн хүчирхийлэлд оруулах, өлсгөх, цангаах, орон гэрээс нь хөөх г.м/ илэрнэ.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэх замаар харгис хэрцгий харьцсаны улмаас хохирогч амиа хорлосон бол нийлмэл гэмт хэрэг гэж үзэж, аль тохирох зүйлээр давхар зүйлчилнэ.

Гэмт хэрэг үйлдэх замаар байнга харгис хэрцгий харьцсан эсэх нь хэргийг зүйлчлэхэд нөлөөлөхгүй бөгөөд нэг удаагийн гэмт үйлдлийн улмаас хохирогч амиа хорлосон байхад Эрүүгийн хуулийн 95 дугаар зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

6. Хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-д заасан “**нүүрийг засрашгүй эвдэж**” гэдэгт нүүрний гэмтэл, сорви, эмгэг өөрчлөлт нь ердийн явцаар арилж бүдгэрэхгүй, мэс ажилбарын эмчилгээ зайлшгүй хийх шаардлагатай болсныг ойлгох бөгөөд энэхүү гэмтэл, сорви, эмгэг өөрчлөлт нь засрах эсэхийг шинжээчийн дүгнэлтээр тогтооно.

Мөн зүйл, хэсэгт заасан “**дүрсийг алдагдуулсан**” гэж хүний нүүрний төрөлхийн хэлбэр болон гаднах төрх нь хэвийн байдалдаа эргэн орох боломжгүйгээр өөрчлөгдсөн байхыг хэлнэ.

Шинжээчийн засрашгүй гэж тогтоосон уг гэмтэл нь дүрсийг алдагдуулсан эсэхийг мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтооно.

7. Мөн зүйлийн 96.2.8-д заасан “**тохуурхан даажигнах**” гэж хүний нэр төр, алдар хүндийг гутаасан аливаа үйлдлийг хэлнэ.

Энэ зүйл, хэсэг болон хуулийн 98 дугаар зүйлийн 98.2, 100 дугаар зүйлийн 100.1-д тус тус заасан “**зовоон тарчлааж**”, “**зовоон тарчлаах шинжтэй**”, “**тарчлаах шинжтэй**” гэдэгт бие махбодийн болон сэтгэл санааны шаналгаа, өвдөлт үүсгэсэн аливаа үйлдэл хийсэн байхыг ойлгоно.



8. Хуулийн 96 дугаар зүйлийн 96.2.8-д зааснаас бусад хүндрүүлэх нөхцөл байдлуудыг Улсын Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 5-д зааснаар ойлгож хэрэглэнэ.

9. Хуулийн 100 дугаар зүйлийн 100.1-д заасан “байнга зодох” гэж тодорхой нэг хохирогчийн эсрэг чиглэсэн, хэвшмэл маягтай, гурав ба түүнээс дээш удаа бие махбодийн хүчирхийлэл хийсэн байхыг хэлнэ.

10. Хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1-д заасан “хүч хэрэглэж”, “хүч хэрэглэхээр заналхийлсэн” гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 23-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгож хэрэглэнэ.

11. Хуулийн 102 дугаар зүйлийн 102.1-д заасан “шаардлага хангаагүй нөхцөл” гэж Донорын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон шалгуур үзүүлэлтэд нийцээгүйг хэлнэ.

12. Хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 105 дугаар зүйлийн 105.3-т тус тус заасан “өөр замаар” гэдэгт цус, цусан бүтээгдэхүүн өгөх, амьд донор болох, өөрөө ашигласан зүү тариураа бусдад хэрэглүүлэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, садар самууны бусад үйлдэл хийх, ариун цэврийн дэглэм зориудаар сахихгүй байх зэргийг хамааруулан үзнэ.

13. Хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1-д заасан “хүнд хор уршиг” гэж их ба онц их хэмжээний хохирол учирсан, хүний амь нас хохирсон, хөгжлийн бэрхшээлтэй болсон, сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, амиа хорлоход хүргэсэн, бие махбодид нь хүнд гэмтэл учирсан зэргийг хэлнэ.

Мөн зүйлийн 104.2-т заасан “гэм хор” гэдэгт бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг ойлгоно.

14. Хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-т заасан “хайнга хандсан” гэдгийг Улсын Дээд шүүхийн 2009 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 22 дугаар тогтоолын 5-д зааснаар ойлгож хэрэглэнэ.

15. Хуулийн 106 дугаар зүйлийн 106.1-д заасан “хүндэтгэх шалтгаангүйгээр” гэж эрүүл мэндийн байдал, эр гэрт нь ганигдал гарсан, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан бусад гамшиг тохиолдсон, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх

шаардлагатай эм, тариа, багаж, тоног төхөөрөмж байгаагүй зэрэг хувь хүнээс өөрөөс нь үл хамаарах бусад нөхцөл байдлыг хэлнэ.

Мөн зүйл, хэсэгт заасан “зохих ёсоор биелүүлээгүй” гэдэгт Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2, 26.1.3-т заасан үүргээ гүйцэтгээгүй байхыг ойлгоно.

16. Хуулийн 107 дугаар зүйлийн 107.1-д заасан “амь биед нь аюултай нөхцөл” гэж байгалийн болон нийтийг хамарсан бусад гамшиг тохиолдсон, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, гэмт халдлагад өртсөн, эрүүл мэндийн /сэтгэцийн болон бусад хүнд өвчтэй г.м/ болон хувийн /бага насны хүүхэд, өндөр настай хүн г.м/ бусад шалтгаанаар үхэлд хүрч болзошгүй байдал бодитойгоор бий болсныг хэлнэ.

17. Мөн зүйлийн 107.2-т заасан “халамжлах үүрэгтэй” гэдэгт хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр болон гэрээ, хэлцлийн үндсэн дээр энэхүү үүргийг хүлээсэн аливаа этгээд хамаарна.

Энэ зүйл, хэсэгт заасан “амь биед нь аюултай байдалд зориуд оруулсан” нь гэм буруугийн санаатай хэлбэрээр илэрнэ.

18. Хүний биед учирсан гэмтлийн зэрэг, эрүүл мэндийг сарниулсан хугацаа болон хөдөлмөрийн чадвар алдагдалтын хувийг зөвхөн шинжээчийн дүгнэлтээр тогтооно.

19. Хуулийн 93 дугаар зүйлийн зарим заалтыг Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 14, мөн хуулийн 91 дүгээр зүйлийн зарим заалтыг Улсын Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор тус тус тайлбарласан болохыг дурьдсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

С.НЯМЖАВ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: torin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 2.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487